

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 дугаар сарын 17

Дугаар А/25

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4.10 дахь заалт, Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 56 дугаар тогтоол, Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит есдүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, 2023 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.2023 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Хурлын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан, иргэд олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга (М.Чанцалням)-д даалгасугай.

ДАРГА

Ч.МЭНДСАЙХАН

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын 2023 оны дугаар сарын-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас 2023 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

Д/д	Төсөл, арга хэмжээний жагсаалт	Хугацаа		Төсөвт өртөг (төгрөгөөр)	2023 онд санхүүжих дүн (төгрөгөөр)
		эхлэх	дуусах		
1	Дүүргийн нутаг дэвсгэрийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх	2023	2023	200,000,000	200,000,000
2	Дүүргийн өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих, сургагч багшаар бэлтгэх цогц хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ	2023	2023	150,000,000	150,000,000
3	Монгол ахуй төсөл	2023	2023	100,000,000	100,000,000
4	Хурлын хуралдааны цахим программ хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ	2023	2023	50,000,000	50,000,000
5	Дүүргийн нутаг дэвсгэрийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг нэмэлт агуулгаар баяжуулан шинэчлэн боловсруулж хэвлэх, англи хэл рүү орчуулан хэвлэх, түүхэн товчоон хийх зөвлөх үйлчилгээ	2023	2023	124,000,000	124,000,000
Нийт дүн					624,000,000